



## ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

**ЭХЭМҮТ-ийн 2026 оны эмнэлгийн тоног төхөөрөмжид их засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, үйл ажиллагааг зохион байгуулах тухай**

Эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай түргэн шуурхай үзүүлэх, байгууллагын санхүүгийн удирдлагын үр дүнг сайжруулж, ил тод байдлыг хангах, нөхцлийг бүрдүүлэх, өмнөх жилүүдэд буй болсон чадавх ба нөхцлийг улам дээшлүүлэх зорилгоор Монгол улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 45, 46, 47 дугаар зүйл заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. Төвийн 2026 оны эмнэлгийн тоног төхөөрөмжид их засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах нээлттэй тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог дор дурьдсан гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:  
Нарийн бичиг:  
Гишүүд:

Э.Өлзийжаргал /ХАБЭА хариуцсан ажилтан/  
Б.Пүрэвцэцэг /ЭТТА-ны дарга/  
Б.Бадамгарав /ЭТТА-ны инженер/  
Т.Мөнхзаяа /Олон нийтийн хөгжилд их үйлс сургалт, зөвлөгөө өгөх төв ТББ/  
Ц.Ганбаатар /Анагаах ухааны технологи инновацийн хөгжлийн төв ТББ/

2. Худалдан авалтыг зохион байгуулах ажлын бэлтгэлийг сайтар хангах, хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тооцоолох, техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа төвийн тасаг нэгжүүд, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон төвийн асуудал эрхэлсэн дэд захирлуудын санал хүсэлт, зөвлөмжийг тусгах, тендерийн үйл ажиллагааг зохион байгуулах бүхий л үе шатыг хуульд нийцүүлэн зохион байгуулах, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг бичгээр гарган Эрх бүхий албан тушаалтан /Э.Мөнхшүр/-д гаргаж бүртгүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Пүрэвцэцэг/- т үүрэг болгосугай.

3. Эмнэлгийн тоног төхөөрөмжид их засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж, хэрэгсэл худалдан авах төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тендерийн үйл ажиллагааг цаг хугацаанд нь түргэн шуурхай зохион байгуулж, шалгаруулан, гэрээ байгуулан ажиллахыг Тендерийн үнэлгээний хорооны дарга /Э.Өлзийжаргал/, үнэлгээний хорооны нийт гишүүдэд даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан /Б.Болор/-д даалгасугай.

ЗАХИРАЛ 

Ж.ОТГОНБААТАР

1606060230